



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН  
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2013 оны 09 сарын 02 өдөр


Дугаар 02


Улаанбаатар хот

Г  
МУИС-ийн 2013-2014 оны хичээлийн жилийн  
сургалтын болон оюутны байрны төлбөрийг  
шинэчлэн тогтоох тухай

МУИС-ийн Удирдах зөвлөлийн 2013 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн хурлын шийдвэрийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн төв байгууллагын хүсэлт, бүрэлдэн бий болсон бусад хүчин зүйлсээс үүдэн 8 дугаар сарын 13-ны өдрийн хурлаар дахин хэлэлцэж, шийдвэрлэснийг үндэслэн ТОГТООХ нь:

1. МУИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын бакалаврын түвшний сургалтын төлбөрийг нэгдүгээр хавсралтаар, ахисан түвшний сургалтын төлбөрийг 2012-2013 оны хичээлийн жилд мөрдөж байсан түвшинд хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. МУИС-ийн оюутны байрны төлбөрийг 350,000 төгрөгөөр тогтоосугай.
3. Хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангах, олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулахыг МУИС-ийн захирал (А.Галтбаяр), Эдийн засаг, хөгжлийн бодлогын асуудал эрхэлсэн дэд захирал (Ч.Нарантуяа) нарт үүрэг болгосугай.





МУИС-ийн Удирдах Зөвлөлийн 2013 оны  
07 дугаар сарын 01 өдрийн 02 дүгээр  
тушаалын нэгдүгээр хавсралт

УАД0072 9104399

**2013-2014 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН БАКАЛАВРЫН ТҮВШНИЙ  
СУРГАЛТЫН ТӨЛБӨР**

№	Бүрэлдэхүүний сургууль (бүлэг хөтөлбөрүүд)	Анги	Хичээлийн жилийн суурь хураамж /төгрөг/	Нэг багц цагийн төлбөр /төгрөг/
I	ЭЗС (бүх хөтөлбөрүүд)	I	200,000	65,900
		II-IV	200,000	40,900
II	ГХСС, ОУХС, МТС, ХЗС (бүх хөтөлбөрүүд) ГГС (газар төлөвлөлт, зураглал, хүрээлэн буй орчин, геологийн бүлэг хөтөлбөрүүд), МКС (компьютерын ухааны бүлэг хөтөлбөрүүд), ХС (худалдаа үйлдвэрлэлийн менежментийн бүлэг хөтөлбөрүүд)	I	200,000	55,900
		II-V	200,000	39,900
III	ФЭС, ХХИС, ББС, МХСС, НШУС, УБС (бүх хөтөлбөрүүд) МКС, ГГС, ХС (дээр дурьдснаас бусад хөтөлбөрүүд)	I	200,000	47,900
		II-IV	200,000	38,900
IV	Завхан, Орхон сургууль	I-IV	200,000	36,000